

“БидиСЕК ҮЦК” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2015 оны 03 сарын 26-ны өдөр

Дугаар *ад.*

Улаанбаатар хот

Компанийн 2014 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийн тухай

Компанийн тухай хуулийн 62.12.9 дэх заалт болон хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн 2014 оны үйл ажиллагааны тайлан болон аудитлагдсан санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг баталсугай.

ХУРЛЫН ДАРГА:



/Б.ЛХАГВАДОРЖ/

“БидиСек ҮЦК” ХК-ийн ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2015 оны 03 сарын 26-ны өдөр

Дугаар 03.


Улаанбаатар хот

Ногдол ашиг хуваарилах эсэх тухай

“БидиСек ҮЦК” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2015 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс гаргасан ногдол ашиг тараахгүй тухай шийдвэр, түүний шалтгааныг хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулсан болохыг тэмдэглэсүгэй.

ХУРЛЫН ДАРГА:



/Б.ЛХАГВАДОРЖ/

“БиДиСЕК ҮЦК” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2015 оны 03 сарын 26–ны өдөр

Дугаар 04.

Улаанбаатар хот

Команийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай

“БиДиСЕК ҮЦК” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2015 оны 03 дүгээр сарын 26-ны өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүнд олонхийн санал авсан:

Ердийн гишүүдэд:

1. Д.Даянбилгүүн
2. Б.Лхагвадорж
3. Н.Батгэрэл
4. Жеймс Пассин
5. Philip Khoury

Хараат бус гишүүдэд:

6. Б.Энхбаяр
7. Хитоши Тани
8. Д.Амгаланбаяр
9. Б.Амарсанаа

нарыг тус тус Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр сонгосугай.

ХУРЛЫН ДАРГА:



/Б.ЛХАГВАДОРЖ/

“БиДиСЕК ҮЦК” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2015 оны 03 сарын 26–ны өдөр

Дугаар 05


Улаанбаатар хот

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2015 оны зардлын төсөв батлах тухай

“БиДиСЕК ҮЦК” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2015 оны 03 дугаар сарын 26 - ны өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2015 оны зардлын төсвийг хавсралтаар нийт 59,600,000 төгрөгөөр баталсугай.
2. Компанийн гүйцэтгэх удирдлагын зардалын төсөвт хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн цалин урамшууллын хороонд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА:



/Б.ЛХАГВАДОРЖ/

“БиДиСЕК ҮЦК” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2015 оны 03 сарын 26-ны өдөр

Дугаар 06


Улаанбаатар хот

Компанийн нэрэнд өөрчлөлт оруулах тухай

Компанийн тухай хуулийн 62.1.1, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 24.7, компанийн дүрмийн 3.13.1-д заасны дагуу “БиДиСЕК ҮЦК” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2015 оны 03 дугаар сарын 26 - ны өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “БиДиСек” ХК-ийн оноосон нэрийг “БиДиСек ҮЦК” ХК байхаар өөрчилсүгэй.
2. Уг өөрчлөлтийг компанийн дүрэмд тусгах болон улсын бүртгэлийн газарт бүртгүүлэн ажиллахыг Гүйцэтгэх захирал /Д.Даянбилгүүн/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА:



/Б.ЛХАГВАДОРЖ/

“БиДиСек ҮЦК” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2015 оны 03 сарын 26-ны өдөр

Дугаар 07.


Улаанбаатар хот

Компанийн бизнес төлөвлөгөө, татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тодотголын тухай

“БиДиСек ҮЦК” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2015 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Шинээр татан төвлөрүүлсэн хөрөнгөтэй холбоотойгоор “Хавсралт 1”-ээр танилцуулсан компанийн бизнес төлөвлөгөө, татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын төлөвлөгөөний дагуу ажиллахыг Гүйцэтгэх удирдлага /Д.Даянбилгүүн/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА:



/Б.ЛХАГВАДОРЖ/

“БиДиСек ҮЦК” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2015 оны 03 сарын 26-ны өдөр

Дугаар 08.

Улаанбаатар хот

Үнэт цаасны танилцуулгын өөрчлөлтийн тухай


“БиДиСек ҮЦК” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2015 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

2. Компанийн танилцуулсан үнэт цаасны танилцуулгын өөрчлөлт /Хавсралт-1/-ийн дагуу үйл ажиллагаагаа явуулахыг Гүйцэтгэх захирал /Д.Даянбилгүүн/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА:



/Б.ЛХАГВАДОРЖ/



“БиДиСЕК ҮЦК” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2015 оны 03 сарын 26-ны өдөр

Дугаар 09.

Улаанбаатар хот


Компанийн зарласан болон гаргасан хувьцааны тоог тогтоох тухай

Компанийн тухай хуулийн 31.2.2, 33.3, 42.1, компанийн дүрмийн 3.21.3-д заасны дагуу “БиДиСек ҮЦК” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2015 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 6 тоот тогтоолын дагуу компанийн нэмж гаргахаар бүртгүүлсэн 6,000,000 ширхэг хувьцааг компанийн дүрэмд бүртгэн зарласан хувьцааны тоо ширхэгийг 17,000,000 байхаар бүртгэсүгэй.
2. Компанийн гаргасан хувьцааны тоог 13,477,536 ширхэг хувьцаа, хувь нийлүүлсэн хөрөнгийг 1,347,753,600 төгрөг болгон өөрчилсүгэй.
3. Компанийн зарласан болон гаргасан хувьцаатай холбогдох өөрчлөлтийг компанийн дүрэмд оруулан бүртгүүлсүгэй.
4. Компанийн зарласан хувьцаанаас гүйлгээнд гаргах, эзэмшүүлэх, хувьцааны тоо, гаргах хугацаа, нөхцлийг тогтоох эрхийг Төлөөлөн Удирдах Зөвлөлд олгосугай.

ХУРЛЫН ДАРГА:

⑤



/Б.ЛХАГВАДОРЖ/

“БиДиСЕК ҮЦК” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2015 оны 03 сарын 26-ны өдөр

Дугаар 10.

Улаанбаатар хот

Компанийн дүрэмд өөрчлөлт оруулах тухай

Компанийн тухай хуулийн 17.1, 62.1.1-д заасны дагуу “БиДиСек ҮЦК” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2015 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Нэмэлт хувьцаа гаргасан болон компанийн нэрэнд нэмэлт өөрчлөлт оруулж байгаатай холбогдуулан компанийн дүрэмд /Хавсралт 1/-ийн дагуу өөрчлөлт оруулсугай.
2. Компанийн дүрмийн өөрчлөлтийг Улсын бүртгэлийн газарт бүртгүүлэн ажиллахыг Гүйцэтгэх захирал /Д.Даянбилгүүн/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА:

6



/Б.ЛХАГВАДОРЖ/